# “Болор цом” хийгээд цагийн ханш

Бичсэн turuu
2018 оны 1-р сарын 12, Баасан гариг, 19:21




“Болор цом – 35” наадам онгорогч оны 12 сарын дундуур Говь-Алтай аймагт болжээ. Мон 2017 оны тэргvvн сард Дорнот аймагт тvvний омнох жил Тов аймаг за тэгээд Архангай гэх мэт хэд хэдэн аймгаар аялан зохиогдсон энэ наадмыг нутагтаа зохион байгуулаагvй аймаг ч нэлээд байх шиг. Тэдэн онд тэр аймагт юм уу хотод зохион байгуулна гэсэн урьдчилсан тов, толовлолт байдаггvй ч, зохион байгуулалтанд шаардагдах зардал свйтгэлийг нь гаргаж чадсан аймаг хотуудад тухайн, тухайн vедээ зохион байгуулагдаад явдаг бололтой.

Анх санаачилснаас хойш 35 жилийн туршид тодий удаа явагдаж байгаа гэдгээрээ, бас Монгол улсын тvвшинд жил бvр явагдаж хэвшсэн ганц том vйл явдал гэдгээрээ ч энэ наадам олонд нэгэнтээ танил дасал болсон “эд”. Зохиогдох болгондоо уг наадмын тайзан дээр шvлэг уншсан эрхэмvvдээс нэгийг нь шалгаруулан, гарт нь “цом” атгуулж, ламын буюу буддагийн шашны ёсонд “яруу эгшигийн (урлагийн) бурхан (тэнгэр) хэмээгдэх Янжинлхам бурханы зурмал, хатгамал хорог, монгон шагнал бас бус зvйлээр мялаах агаад, жил бvрийн энэ шагналыг хvртэгсэд бултаар “Болор цомын эзэд” хэмээн оргомжлогдсоноор олон нийтийн дунд нэр хvнд нь свpхий оргогдох ажээ. Болор цом наадмын хувьд яруу найргийг, яруу найрагчдийн оорсдийнх нь дуудан уншсанаар, чухам амьдаар нь хvмvvст хvргэж, найрагч vзэгчдийг хооронд нь уулзуулдагаараа ихээхэн сонирхолтой. Уг наадмын онцлог толвийг хамгаас тодруулж буй оор нэг зvйл нь найрагчдийг хооронд нь уралдуулж, тэднээс цоон хэдийг нь шалгаруулан оргомжилж, онцгой гэсэн нэгэнд “титэм омсгодог” явдал богоод vvгээрээ олны сонирхолыг ихээр дагуулдаг болов уу гэж бодогдох. Хvмvvс чухам л энэ онцлогт нь илvv татагдаж, тэр тусмаа тухайн жилд Болор цомын эзэн болсон найрагчийн ойр дотныхон, нутаг усныхан, тvvнд хамаатай нохoд нь ихэд бэлэгшээж, хоорон шуугих нь жам мэт болсон билээ. Эдгээрийг орхин, энд vгvvлэх гэсэн нэг зvйл юу гэвэл олон нийтийн дунд энэхvv наадмыг яруу найргийн бvтээлvvдийн зэрэг дэв, чанар чансааг тогтоох шалгуур мэт, цаашилбал улсын хэмжээн дэх яруу найргийн гол тодорхойлогч хvчин зvйл мэт ойлгох хандлага нэгэнт бий болоод улам архагших шинжтэй байгаа нь энэхvv “Болор цом” наадмын тухайд анзаарвал зохих дохио сануулгыг огоод байх шиг санагддаг. Yvнийг тодлон илэрхийлэх vй тvмэн шинж байдлыг амьдрал дундаас харж болох агаад, хамгийн наадын жишээ гэвэл хvмvvс яруу найргийн ном бvтээлийг дэлгvvрээс худалдаж аваад, эсвэл номын санд суугаад ч юм уу, хаа нэгтээд шимтэн унших нь байтухай хэрэг болгож сонирхох нь жилээс

жилд ховордсоор, нvдний гэм болох шинжтэй. Биднийг хvvхэд ахуйд ном бол ертонцийг харах цонх, урлагийн сонгодог дээд гурван оргил бол яруу найраг, хогжим, уран зураг юм” гэх мэтээр оюуны суу билэгтнvvдийн vлдээсэн сэтгэгдэл, (хэлсэн vгс) зэргийг анддаггvй, ихэд эрхэмлэн дээдэлдэг, уншиж гэгээрэх нь оюун ухааныг тэлэх, хvнийг хvн болгох чухал ололт гэж итгэдэг байсан бол одгоо “Болор цом” тодийхноор яруу найргийг толоолvvлэн ойлгох, ведио клип ч юм уу, аль нэг хамтлаг эсвэл хувь уран бvтээлчийн цомог сонсож урлагийн таашаалыг эдлэх зэрэг нь соёлын хэмжvvр болох шинжтэй. Цаашилбал /24 tsag.mn/ -цахим сайтад бичсэнчилэн “тус наадмын ханш хаданд гарч, тvрvvлэх хvнд нутгийн зовлол нь хэдийнэ бэлэг бэлдэж, оргомжлолоо хэвлvvлчихсэн байх, орон сууц, унаа машин огох хvртэл нутаг нуга, ахан дvvсээрээ хол болох”, “Болор цомын эзэн” гэхийг тухайн салбарт бvтээсэн бvтээлээ vнэлvvлж буй дээд хэлбэр, ондор цол хэргэм мэтээр тосоолох зэрэг нь бодитой vзэгдэл болж тогтсон. Энэ нь мэдээжийн хэрэг цаг vеийнхээ ханшийг дагаж буйгийн илрэл хэдий ч vр нолоо нь нийгэмд яаж тусаж байна гэдгийг юуны тvрvvнд уран зохиолын асуудлыг эрхэлсэн vндэсний байгууллага болох Монголын зохиолчдын эвлэл хийгээд торийн соёлын бодлогыг тодорхойлох, хэрэгжvvлэх чиг vvрэг бvхий нохдvvд эрэгцvvлж, тунгааж vзэх ёстой болов уу.
Энд сануулбаас зохих оор нэг зvйл гэвэл “Болор цом”-ыг зохион байгуулахдаа тухайн наадмын тэргvvн болон тэргvvлэх бvтээлvvд хийгээд шvлэгчид, яруу найрагчдыг шалгаруулан тодруулж буй арга хэлбэр нь нэн “хонгомсог” санагддаг. Юу гэвэл уран зохиолын тэр дундаа яруу найргийн бvтээл гэдэг бол дээр цухас дурьдсанчилан vндэстэн, ард тvмний оюуны далайг сэлбэж буй хамгийн гvн гvнзгий, нарийн чанадын эх олонлогуудаас бvтэж бий болдог, хязгааргvй агууламж бvхий онцгой нэгэн цутгалан (торол хэлбэр). Тvvнийг уншиж ойлгох, сонсож мэдрэх, vр, “авшиг”-аар нь мэдрэмж, сэтгэлээ хоглон сэлбэх, ухаан санаагаа тэлэх нь vнэтэй болохоос, уралдуулж, байр эзлvvлж, нэг хэсгийг нь оргомжлон хооргож, ногоо хэсгийг нь vл ойшоон урам зоригийг нь молийлгох нь тийм ч vнэ цэнэтэй биш баймаар санагддаг. Хvн зоны оюун сэтгэлийг гийгvvлэхvйц сайн шvлэг зохиолыг vнэлэх оргомжлох нь зvйн хэрэг байлгvй яахав. Гэвч яг тэгж чадаж байгаа юу гэдэгт асуудал бий. Яагаад ч юм энэ тухай бодох болгонд хэдэн мянганы омно улирч онгорсон боолын нийгмийн vе дэх “мэсчин боолууд”-ын тулаан, одгоо цагийн гардан тулааны тэмцээнvvд санаанд орох нь бий. Хэдийгээр гадна харагдах байдлаараа тэс омноо зvйлvvд авч, оролцогчид нь оорт байгаа биеийн хvч чадал, овсгоо самбаа, мон оюуны чадвар, билэг авьясаа vнэлэн тэмцэлдэж, шохоорхон зугаацагчдын тоглоом болгох замаар шагнал горилж буй мон чанар нь ав адилхан юм.
Ер нь оюуны хийгээд зvрх сэтгэлийн vрээс бий болсон аливаа бvтээл туурвилийг оноо огч байр эзлvvлнэ гэдэг бидний бодоход тун чиг шаггvй асуудал баймаар. Бондгор дотроо бодож сэтгэж байгаа, сэтгэл санаандаа таалж, мэдэрхийлж байгаа тэр нарийн чанд ертонцийн vvсвэр язгуур, орнол, vр дагаварыг нь хондлонгоос шvvгч ч юм уу хэн нэгэн шууд л нэвт шувт таниад, зvгээр ч vгvй оноо тавиад дvгнээд байна гэхээр санаанд ер буудаггvй юм. Тэгэхдээ хvрвэл монхvv шvvгчдийн тийм асар тvвэгтэй, дээд мэдлэг, мэдрэмж, бараг л “ид шид” шаардсан ходолморийг vнэлэх vнэлэмж нь тодий хэр ондор байх хэрэгтэй байх. Яруу найрагчдын шvлэг зохиолыг vнэхээр л чанар чансаагаар нь эрэмблэж, олон тvмний таньж мэдэх vvргийг хонговчилж огохийн толоо ийнхvv шvvн тунгаах vлэмж нарийн тvвэгтэй ажлыг гvйцэлдvvлж байна гэж vзвэл шvvгчдийн ходолморийн vнэлгээ нь тvрvv байр эзэлсэн нэг найрагчийн хvртэж буй шагналын дайны байдаггvй юм аа гэхэд, ядаж л дохолцохvйц байх хэрэгтэй биз ээ.
Гучин таван жилийн турш энэ наадмыг зохион байгуулсан эрхэмvvд маань энэ мэтийг ер

авч vздэггvй нь ямар учиртайг гадарлах юм алга, Магадгvй шvvгчид нь хэтэрхий нэрэлхvv болоод, зохион байгуулагчид нь их л бvдvvн бааз байж болох, эс богоос оор ч шалтгаан байж болох л доо. Оор шалтгаан гэснээс жил бvрийн болор цомд тэргvvлсэн хийгээд дээгvvр эрэмбэлэгдсэн (эхний байруудад орсон) шvлэг зохиолын талаар хvмvvс янз бvрийн санаа бодлууд илэрхийлдэг богоод сvvлийн жилvvдэд чанар чансаа нь муудаж, шvvлтийн vр дvн нь нvдээ олохгvй байгаа, харин ч онцолж тодруулбал зохихууц, зарим сайн шvлэг уншсан найрагчид байр эзлэхгvй vлдэх зэргээр хэлмэгдэх явдал ч элбэг байна гэхчилэн сонжимтгой хандлага давамгайлах болсон. Энэ тухайд нэн тодорхой баримтуудыг дурьдаж болох авч, моноох найрагчид, шvvгчдийн нэр торд халгаатайг бодолцон, тодруулж бичихээс зайлсхийв. Мэдээж энэ нь зохион байгуулалтын арга барил, дээр цухалзуулсанчилан бас бус шалтгаанаас улбаатай гэдгийг дахин тодотгохыг хvснэ. Тvvнчилэн оноогийн Монголын нийгэм дэх сэтгэлгээний хандлага, нийгмийн тогтолцооны болон улс тор гэх мэтийн нолоо сvvдэр гvнзгий шургасаны vр дагавар гэдэг нь ч тодорхой.
Тухайлахад зохион байгуулж буй байгууллага нь монго санхvvгийн хувьд бололцоо муутай учир хандив тусламжийн журмаар хоронго босгох арга замыг голчлон хэрэглэдэг бололтой богоод, vvнээс нь болоод “Болор цом” наадам маань санхvvжvvлэгчээс тодорхой хэмжээгээр хараат байдалтай явагддаг. Тухайн чиглэл рvv хандсан торийн бодлого дутмаг, БСШУС-ын яаманд Соёл урлагийн газар гэж бий авч, уран бvтээлийн нарийн ширийнийг сайтар мэдэрдэг, тэр талын бодлогыг огоожтэй болгохын толооноо чин сэтгэлээсээ зvтгэл гаргаж ажиллахуйц уран бvтээлчийн толоолол тэнд ер ажилладаггvй. Дээр нь vндэстэн ард тvмний хамгийн эрхэм зvйл болох соёлын асуудлыг боловсрол, шинжлэх ухааны салбарын дагуул, хавсрага маягаар авч явдгаас соёл, утга зохиол, уран бvтээлийн чиглэлийн торийн бус байгууллагуудад дорвитой дэмжлэг ирдэггvй. Соёл уран бvтээлийн асуудлыг арилжааны журмаар хогжvvлэх ёстой гэсэн “барууны” орнуудын vзэлт, санаа бодлыг торийн бодлогын чиг баримжаандаа хуулбар болгон хэрэглэсэн нь vндэсний онцлогтой тэр бvр зохицдоггvй, тvvгээр ч барахгvй манай нийгэмд хамт олны болон хувь хvний ходолмор зvтгэл, авъяас чадварыг vнэлэх урамшуулах асуудлыг арилжаа наймаа болгон хувиргасан, “та тийм, тийм амжилт гаргасны учир тийм шагнал хvртээлээ” гэж мэдэгдсэнээ, “та дансанд тэдэн тогрог тушаагаад, шагналаа ирж авна уу” гэх явдал ч гардаг болсон, алив бvхэнд улс торийн намын болон бvлэглэлийнхний гар хол сав л хийвэл шургалж, тэдний эрх ашгийн тоглоом болгож хувиргахыг санаархаж байдаг гэхчилэн олон хvчин зvйлийг авч vзэж болно.
Эл бvхнийг орхин vндсэн асуудалдаа орвоос, цаашид хэрхэх бил ээ? гэсэн асуулт тулгарах нь мэдээж. Ямар ч асан зохион байгуулах арга барилаа шинэлэг санаа оноогоор баяжуулж, оорчилж, сайжруулах эрэл хайгуулыг тасралтгvй хийж байх хэрэгтэй гэдэгтэй хэн хvн санал нэгдэх болов уу гэж бодно. Аль ерэн хэдэн оноос л яруу найргийн наадам тэмцээнийг зохион байгуулахдаа илvv оновчтой санаа, оор арга барилыг эрэлхийлэх явдал vзэгдэж байсныг санах хэрэгтэй байх. Тухайлахад 1996 онд шиг санана, Улаанбаатар хотод “Анти мир” нэртэй яруу найргийн наадам зохион байгуулагдсан богоод тэр наадам дээр шvvгчдийн шvvлтийг илvv шудрага болгох нохцлийг хангах талаар шинэ хандлага хэрэглэж байв. Тэрээр тэмцээнийг шvvх шvvгчдийг бие биенээс нь хол, хол зайтай, танхимын суудлын эгнээ тус бvрд нэг нэгээр нь, хvмvvсийн дунд суулган, тэндээс нь оноо оргvvлэх, мон зэрэгцээд vзэгчдийн дунд санал асуулга явуулах аргаар vзэгчдийн таашаал хvртсэн шvлгийг тодруулж байсан нь бас нэг дэвшилттэй санаа байсан боловч, ийм байдлаар наадам зохион байгуулах явдлыг

цааш vргэлжлvvлсэнгvй орхисон. Басхvv Бэгзийн Явуухулан найрагчийн мэндэлсний ойгоор Завхан аймагт зохиогдсон наадам, Үндэсний тусгаар тогтнолын толоо тэмцэгч Б.Чингvнжав баатрын мэндэлсний 300 жилийн ойгоор Ховсгол аймаг Морон хотод зохиогдсон яруу найргийн наадам зэрэгт, оноо огч, нэг, хоёр ... гэж байр эзлvvлэхээс зайлсхийж, онцлох ёсон шvлгийг шvvгчдийн сонголтоор тодруулан, тус бvрд ижил тvвшиний шагнал хvртээж оргомжилсон туршлагууд бий.
Эдгээр нь дээр vгvvлснээр яруу найргийн бvтээлийг оноогоор дvгнэж, дэс дараалуулан байр эзлvvлэх нь оновчтой арга зам биш гэдгийг тодий vеэс л хvмvvс ажиглаж байсны илрэл гэж болно. Ер нь урлагийн бvтээлийг тэр тусмаа оюуны багтаамж ихтэй, олон зvйлийн агуулга, онго аяс, цар хэмжээ, донж маягийн илэрхийлэл болж байдаг яруу найраг мэтийг шvvнэ гэдэг тийм алга урвуулах тодий шийдвэр гаргачих, амар хялбар асуудал биш гэдгийг нэг хоёр удаагаас огсvvлээд нэжгээд олон удаа ийм vvрэг хvлээж vзсэн эрхэмvvд хэлvvлэлтгvй мэдэх байх. “Болор цом” наадмын нолоо, сvvдэр орон даяр ихээхэн тvрцтэй дэлгэрч, аймаг орон нутаг бvрд иймэрхvv жижиг наадмуудыг уламжлал болгон явуулахаас гадна торийн боловсролын болон хvvхэд залуучуудын асуудал хариуцсан байгууллагаас дунд сургуулийн сурагчдын дунд улсын хэмжээгээр ийм наадмыг жил бvр бvх аймаг хотуудад болон нийслэл хотод гэсэн хоёр vе шаттайгаар зохион явуулдаг нь мон л “Болор цом”-ын зохион байгуулалтыг дууриасан арга хэлбэрийг хэвшил болгосон. (сvvлийн жилvvдэд хоёр жилд нэг удаа явагддаг болгожээ). Тэрчилэн их, дээд болон дунд сургуулиуд, аймаг хотуудын зарим соёлын байгууллага, Номын сан гэх мэтээс ч оюутан, сурагчдын дунд иймэрхvv наадам, тэмцээнийг явуулах нь олонтоо болсны далбаан дор “мань мэтс” нь зарим уралдаан наадамд шvvгчээр уригдаж, “бурхангvй газрын бумба галзуурна” гээчийг хийж явсан маань бас ч гэж наана, цааныг ажиглаж танихад тустай болсон байж магад.
Молхи миний хувьд эл бvхнээс ажигласнаар бол ийм торлийн уралдаан, наадмыг, нэн ялангуяа хvvхэд освор vеийнхнийг шvvж, ялгаварлан байр эзлvvлснийхээ толоо тэр танхимаас сэтгэл хангалуун, додигор бодолтой гарна гэдэг бараг л vгvй юм билээ. Насанд хvрэгчид ч ялгаагvй, тайзан дээр шvлэг уншсан бvх найрагчид шvvгчдийн шvvлтэнд бvгдээрээ ижил сэтгэл хангалуун vлддэггvй. Тvрvvлсэн нь баярлаж, орхигдсон нь гомдоно. Үндэслэлгvй гомдлолоо гэж vзэх боломж шvvгчдэд бас байхгvй. Тэгэхээр эргээд л ногоо “эрэл, хайгуул”-ын тухай бодох хэрэгтэй болох богоод дээр дурьдагдсан “тvvхэн оролдлогууд”-ыг ч орхиж боломгvй санагдана.
Харин хувь уран бvтээлчийн хувьд оорт бодогддог зарим нэг санаа бодлоо хуваалцваас “Болор цом” болон тvvнтэй тостэй арга хэмжээг зохион байгуулж, найрагчид, олон тvмнийг уулзуулах нь тухайн цаг vеийнхээ тодорхой тvвшин дэх яруу найргийн торх, толвийн тухай тойм тосоолол огох хэмжээнд л болохоос бус, яруу найргийг толоолон, тодорхойлох хvчин зvйл болох учиргvй юм. Тvvнчлэн шалгаруулах арга хэлбэрийн хувьд наадамд уншигдсан шvлгvvдийг хэд хэдэн торлоор (номинац) ангилан, торол тус бvрд онцгойрсон шvлгvvдийг тодруулж болох. Тухайлахад иргэний уянгын, намуун уянгийн, сонгодог яруу найраг, гvн сэтхилгээний, шинэлэг сэтхилгээний, олон нийтийн таашаалд нийцсэн гэх мэт торлvvд байж болох. Шагнал урамшууллын тухайд мэргэжлийн ажлын хэсэг (комисс) тогтоох агаад, хоорондоо тодий их зороотэй бус ойролцоо байх нь зохистой мэт. Монхvv шvvн тунгаах арга ухааны хувьд дээр vгvvлэгдсэн “Анти мир” тэмцээний жишээг улам боловсронгуй болгох замаар хэрэглэж болох мэт санагдах амой. Гэхдээ яруу найргийг олон нийтийн болон vзэж, сонсож байгаа хvмvvсийн хvлээж авч байгаа хандлагаар нэг мор vнэлнэ гэж байхгvй л дээ. Шvvгчид ч нэг мор дvн тавьчихаж

дийлэхгvй гэж боддог. Ер нь яруу найргийг vнэлж дvгнэнэ гэдэг маш харьцангуй ойлголт. Сэдхилгээний асар уужим орон зайд бичигдсэн, ондор твшиний бvтээлийг хvмvvс гvйцэж ойлгохгvйн улмаас таалахгvй байх нь бий, тvvнчлэн урьд омно нь олонтоо давтагдсан байж л байдаг энгийн нэг санааг авч, хэн нэгний хэлбэр загварыг дууриах байдлаар бичигдсэн, эсвэл шvлэгч нь оорийн vзэл бодол тодийг шvлгийн хэлбэрээр илэрхийлсэн /цагаан/ шvлгvvд хvмvvсийн ихэнхэд их аятайхан санагдаж, таалагдах нь тvгээмэл vзэгдэл.
Харин яруу найргийн чиг хандлагыг тандах учир зорилгын хvрээнд ч юм уу, томоохон цогц бvтээлvvдийг онцлон тодруулах, шалгаруулах сэлт бол оор твшиний том асуудал гэж бодно. Одгоо жил бvр явагддаг “Алтан од” шалгаруулалтыг ийм санаагаар хийгддэг гэж боддог ч, зохион байгуулалт, арга барил хийгээд бусад асуудлуудын талаар нь бид мэтэд мэдэх юм алга.
Эцсийн эцэст “Болор цом” ч, “Алтан од” ч, оор бусад наадам, арга хэмжээ ч ялгаагvй яруу найраг, уран зохиолыг тvмэнд тvгээх, Д.Нацагдорж зохиолчийн хэлсэнчилэн “соёлын vрийг тарих”-ын толооноо явагдаж буй vйл хэрэг богоод, нолоо сvvдэр нь хvмvvсийн сэтхилгээг хумих, хэлбэр тодийд баригдаж, гадна онгонд шохоорхон хоорoлхохийг нь хохивлэн дэвэргэх бус, харин ч яруу найраг, уран зохиолын тvгээмэл гvн утга, яруу зохист бvхнийг бодол ухаанаараа шимтэн тунгааж, сэтгэл оюунаа тоголдоржvvлэхэд нь нэмэр хань болохуйц аваас сая vнэ цэнэ нь орших билээ гэсэн эл бvхий санааг олон тvмэнтэй хуваалцахын толооноо vvнийг бичиглэсэн болмуй.

**Хиргис Г.Төрмөнх (яруу найрагч,зохиолч)**